

# ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 06 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар А-114

Улаанбаатар  
хот

## Төсөлд дэмжлэг үзүүлэх тухай

Засгийн газрын 2011 оны 374 дүгээр тогтоолоор баталсан “Мал хамгаалах сангийн хөрөнгийг захиран зарцуулах, тайлагнах журам”-ын 4.2, 4.3, 4.4 дэх заалт, Ажлын хэсгийн 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хурлын тэмдэглэл, мөн өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зөгий үржүүлж буй аж ахуй нэгжүүдэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх” төсөл сонгон шалгаруулалтад тэнцсэн аж ахуйн нэгжүүд, тэдгээрт олгох зээлийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Барьцаа хөрөнгийн шаардлага хангасан аж ахуйн нэгжтэй 5 жилийн хугацаатай, жилийн 3.6 хувийн хүүтэй, эхний жил үндсэн төлбөрөөс чөлөөлөх нөхцөлтэйгөөр зээлийн гэрээ байгуулж, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллахыг Мал хамгаалах сан /Ц.Цэдэндамбаа/-д даалгасугай.

3. Зээл олгоход шаардагдах 35.000.000 /Гучин таван сая/ төгрөгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны А-179 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын 2.35-т заасан зардлаас санхүүжүүлэхийг Мал хамгаалах сан /Ц.Цэдэндамбаа/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Батмөнх/-т үүрэг болгосугай.

САЙД

Б.БАТЗОРИГ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын  
2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн  
А-114 дугаар тушаалын хавсралт

ТӨСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ТЭНЦСЭН АЖ АХУЙН  
НЭГЖИЙН НЭР, ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ

д/д	Аж ахуйн нэгжийн нэрс	Зээлийн хэмжээ /сая төгрөг/
1	“Ангаач зөгий” ХХК	5.0
2	“Ай Эн Эйч” ХХК	5.0
3	“Эм Жи Эл Би” ХХК	5.0
4	“Үүр хайрхан” хоршоо	5.0
5	“Спинел” ХХК	5.0
6	“Шижир Ембүү” ХХК	5.0
7	“Форэко” ХХК	5.0
Нийт		35.0